

Түүх 7 :

Таван талх, хоёр загас

Библийн эшлэл

[Лук 9:16]

Есүс таван талх, хоёр загасыг авч, тэнгэр өөд ширтэн ерөөгөөд, талхыг хувааж, хурсан олонд өгүүлэхээр шавь нартаа өгөв.

Нэгэн өдөр Есүс, Галил нуурын эрэг дээрээс үгийг тунхаглаж байлаа.

Энэхүү сураг чимээг дуулсан хүмүүс бүгд Есүс руу цугларав.

Есүс, хүмүүсийн дундуур явангаа өвчтэй хүмүүсийг эдгээж, Бурханы хаанчлалын талаар ярьж өгч байлаа. Оройхон болоход шавь нар нь Түүн рүү ойртон ирж ингэж хэлэв. “Энэ газар зэлүүд мөн цаг хэдийнэ оройтжээ. Хурсан олныг тараан явуулаач.

Тэд тосгодод очиж, өөрсдөдөө хоол хүнс худалдаж авцгааг” гэгцгээв. Есүс ингэж хэлэв.

“Тэд хол явах хэрэггүй. Харин та нар тэдэнд идэх юм өг” гэхэд. Шавь нар хариулав.

“Есүс ээ ~ бидэнд мөнгө байхгүй, мөнгө байлаа ч энэ газраас худалдаж авах хоол хүнс байхгүй байна.

Гэтэл бид хэрхэн хүмүүст идэх зүйл өгч чадах билээ?” Ийнхүү хариулсан шавь нартаа Есүс ингэж айлдав.

“Тэгвэл та нар яваад хүмүүс дундаас идэх зүйл байгаа эсэхийг мэдээд ир.” гэв.

Шавь нар нэг хүүд таван талх, хоёр загас байгааг анзаарав.

Тэгээд шавь нар тэр таван талх, хоёр загасыг хүүтээс аваад Есүст өгөв. Есүс, хүмүүсийг тавь тавиараа хуваагдан зүлгэн дээр суухыг тушаахад тэнд эрчүүд гэхэд л таван мянган хүн болж байв.

Есүс, арвайн таван ширхэг талх болон хоёр загасыг өндөрт өргөн залбирсаны дараа ингэж айлдав.


“Одоо хүмүүст хувааж өг” гэж хэлэв.


Гэтэл тэнд гайхамшигтай зүйл бий болов. Хичнээн ихээр тарааж өгч байсан ч арвайн талх болон загас дундрахгүй л байлаа. Эцэст нь таван мянган хүн бүгд идэж цадсан байлаа.

Тэнд байсан бүх хүмүүс бүгд Есүсийн хүч чадлыг үзэн гайхширцгааж байв.

Есүс шавь нартаа дахин ингэж айлдав. “Идээд үлдсэнийг нь хаялгүй сагсанд бүгдийг хийгээрэй.” гэв.

Тэд үлдсэн хоолоо цуглуулж дуусахад арван хоёр сагс дүүргэв! Цугласан олон болон шавь нарын Есүст итгэх итгэл, хүндэтгэл улам хүчирхэгжиж, тэд Түүнийг дагасаар байв.





Бүтээлч байцгаая 1. Доорх асуултанд хариулаарай.

a. Есүсийн ерөөсөн таван талх, хоёр загасаар хэдэн хүн хооллосон бэ?

b. Бүгд хооллоод үүнээс талх ба загас хэдэн сагс үлдсэн бэ?

c. Иохан 6:1-15 эшлэлийг уншаад хариулаарай. Есүс “Тэдний идэх талхыг бид хаанаас худалдаж авах вэ?” гэж асуухад, Филип болон Андрей нар юу гэж хариулсан бэ?

d. Филип болон Андрей хоёрын хэн нь хүмүүсийг хооллох шийдвэрийг гаргахад дөхөм итгэлийн хариулт өгсөн бэ?

● Дараах библийн эшлэлийг уншаад цээжлээрэй. (Лук 9:16)

Есүс таван талх, хоёр загасыг авч, тэнгэр өөд ширтэн ерөөгөөд, талхыг хувааж,
хурсан олонд өгүүлэхээр шавь нартаа өгөв.

Бүтээлч байцгаая 2. Тавган дотор таван талх, хоёр загасыг зураарай.

